Могой тамгын тухайд

Б.Аззаяа
МУИС. ГХСС

Монгол нутаг дахь хадны зураг, гэрэлт хөшөө, булш бунхан, тахилын цогцолбор, хүн чулуу гэх мэт олон зүйл дурсгал нь үе үеийн түүхийг судлан шинжлэхэд ихээхэн чухал эх хэрэглэгдэхүүн болсоор байгааг судлаачид нэгэнтээ тэмдэглэсэн байдаг. Тэдгээр дурсгалуудаас хэмжээний хувьд бага мөртлөө асар их мэдээлэл агуулдаг нь тамга тэмдэг бөгөөд энэ удаад могой тамгын талаар авч үзье.

Эрдэмтдийн судалгаанаас үзвэл монгол нутагт, хүрлийн үеэс эхлэн хад чулуунд могой дүрслэгдсэн байна. Ц.Доржсүрэн гуай анх олж[1] улмаар 1970 оны зун В.В.Волков, Э.А.Новгородова нар судлан хэвлүүлсэн, Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг Цагаан голын хадны зурагт таван могойг нилээд бодит байдалтайгаар, гэхдээ нүд толгой зэргийг тодорхой гаргалгүйгээр дүрсэлсэн байна[2]. Д.Дорж, Э.А.Новогородова нар Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл уулын Зүүн билүүний хаданд буй могойн зургийг нийтлүүлжээ[3]. Могойг цогнойн өндийсөн байдлаар дүрсэлж, толгой дээр нь дөрвөн цэг хосоор тавьсан байна. Эрдэмтэн Ц.Баттулга Дэл уулын Баруун Билүүний хаданд могой дүрсэлсэн зураг нилээд хэд байдгийг дурдаад дорно дахины домогзүйд могойг этүгэний, лусын амьтан гэж үздэг тул могойн толгой дээрхи цэгийг хур бороoны дусал хэмээн үзэж болох талтай гэжээ[4].

Түрэг, Уйгурын үед холбогдох гэрэлт хөшөө, түүний суурь яст мэлхий, мөн зэл/балбал/ чулуунд сийлсэн тамга тэмдгийг тухайлан судалж утга, агуулга, бэлгэдэл зэргийг тайлбарласан бүтээл цөөн бөгөөд нэн ялангуяа могой тамгын талаар бичсэн зүйл бараг байхгүй бололтой. Эл үеийн гэрэлт хөшөө, зэл чулуу, тахилын хавтан, хадны бичээс зэрэгт хамгийн элбэг тохиолддог нь “Янгир” тамга бөгөөд эрдэмтэд санал нэгтэйгээр түрэгийн Ашина овгийн сүлд тамга гэдэг билээ. Гэтэл түүнээс дутахгүй хүндтэйгээр, янгир тамгатай цуг тохиолдох нэгэн зүйл тамга бол могой тамга юм.

Бидний шүүн үзсэнээр, Чойрын хүн чулууны /эдүгээ Үндэсний Түүхийн музейд буй/ цээжнээ руни бичээс буй бөгөөд түүний баруун талд янгир тамгын дээр могой тамга цохисон буй. Мөн түүнчлэн Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Улхын булан гэдэг газраас олдсон /эдүгээ Төв аймгийн музейн үүдэнд буй/ уран хийц бүхий яст мэлхийний зүүн гуян дээр могой, баруун гуян дээр янгир, Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамд буй Билгэ хааны тахилын цогцолборыг малтан шинжлэх явцад олдсон зэл чулуунаа мөн могой тамга буй[5]. Түрэг судлаач С.Харжаубай “Эртний Түрэгийн II хаант улсын төрийг Ашина, Ашидэ хэмээх хоёр овог ноёрхож байсан бөгөөд Ашина нь тэнгэр шүтлэгтэй, “янгир” тамгатай, Ашидэ нь газар шүтлэгтэй “могой” тамгатай байсан. Энэ нь руни бичгээр бичигдэж үлдсэн дурсгалын мэдээнд:

---

[1] Доржсүрэн Ц, Говь-Алтайн Цагаан голын хадны зураг, -Эртний судлал угсаатны зүйн бүтээл, УБ., 1963, тал.16-19
[2] Дорж Д, Новогородова Э.А, Петроглифы монголии, УБ., 1975, тал.21
[3] Дорж Д, Новогородова Э.А, Петроглифы монголии, УБ., 1975, тал.21
[4] Баттулга Ц, Дэл уулын дурсгал, /МУИС, Түрэг судлалын төвийн гар бичмэлийн сан/, УБ., 2002
[5] Osman Fikri Sertkaya, Cengiz Alylmaz, Tsendiin Battulga, Album of the Turkish monuments in Mongolia, Ankara, 2001, pp.274,168

“tengi teg tengride bolmys bilge qaγan bu ödke olurtym (KTm1) tenri, Umaj, Jer-Sub basa berti erinc (Ton38)” хэмээснээс тодорхой гэжээ[6].

Нэг угсааны хоёр овог өөр өөр тамгатай байж болох боловч харин шүтээний хувьд ялгаатай байх нь нилээд эргэлзээтэй юм. Тэрбээр “Ашина нарын том төлөөлөгчид нь Ел-териш Кутлуг, Бильгэ каган, Кюль-Тегин нар бөгөөд Ашидэгийн том төлөөгөлчид нь Капаган, Тоньюкук, Кюли-чор, Арслан Кутлуг Кюль-Бильгэ каган, Тур-айын, Ел-етмиш Бильгэ каган, Бөгү-каган, Кутлуг болон түүнээс хойшхи Уйгурын хаант улсын бүх каганууд орно” [7] хэмээжээ. Илтириш хааныг нас барах үед хүү Билгэ /7 настай/, Көл тигин /6 настай/ нар бага байсан учир төрсөн дүү Капган /Можоо/ Түрэг улсын хаан ширээнээ суусан гэдэг. Төрсөн ах дүү хоёр өөр өөр овогтой, шүтлэгтэй байхгүй нь мэдээж юм. Тоньюкук ашидэ овгийн хүн байсан бол гэрэлт хөшөөндөө өөрийн овгийн шүтээн могой сийлэх магадлал их бий. Бас уйгурын хаад ашидэ овгийнх бол түрэгийн хаад адил гэрэлт хөшөөндөө могой сийлэх байсан буй за. Гэтэл могойг янгир тамга адил шүтээний хэлбэрээр тусгайлан сийлсэн зүйл алга ажээ.

Бөө мөргөлийн хэрэглэгдэхүүнээс үзвэл эртний монгол, түрэг угсаатан этүгэн, лусыг могойгоор төлөөлүүлэн түүгээр дамжуулан онгод, дээд тэнгэртэй холбогддог гэсэн ойлголт байсан нь бөөгийн өмсгөл дэх могойн чуулганаас тодорхой байна. Энэ тухай О.Пүрэв гуай дурдахдаа: “Монгол бөөгийн шашинтнууд могойг лус, савдагаас онгод-тэнгэрт нөхцүүлэхээр ирсэн элч төлөөлөгч гэж үздэг. Энэ нь хонины ноос, хөвөн зэргийг томж, гадуур нь өнгө өнгийн даавуугаар бүрж, могойнууд дүрслэн, бөөгийн өмсгөлийн үндсэн хэрэглэгдэхүүн болгодог явдлаар илэрдэг. Могойг дүрслэхдээ хийсвэр, бодит гэсэн хоёр үндсэн аргаар дүрсэлдэг ба хийсвэрлэн дүрслэхдээ толгой, хамар, нүд, сүүл зэргийг дүрслэхгүй, зөвхөн зулзган могойгоор төлөөлүүлэн, харин сүүл хэсэгт арьсан цацаг хийдэг ажээ. Могойн ийм дүрслэл хуулар, тува нарын түрэг угсааны болон дархад, хотгойд нарын дунд ихэд дэлгэрчээ. Бодит байдлаар могой гэж танигдахуйцаар толгой, нүд, хамар сүүл зэргийг бодит байдлаар дүрсэлсэн дүрслэл барга, хамниган, буриад зэрэг Дорнод Монголын бөө нарын дунд элбэг тархсан байна[8]” хэмээжээ.

Могой тамгыг тусгайлан судлаагүй ч эрдэмтэд уйгур угсааны язгууртны нарын тамга гэдэгт санал нэг байдаг. Чойрын хэмээн алдаршсан хүн чулууны цээж гэдэс дээр руни бичгээр нэлээд замбараагүй хэлбэрээр зургаан мөр бичээс сийлснийг анх нэрт түрэг судлаач С.Г.Кляшторный уншиж тайлсан[9] бөгөөд дараа нь 1998 онд Туркийн эрдэмтэн О.Ф.Серткая дахин нягтлан уншжээ[10]. Тэрбээр 1-р мөрийг өмнөх уншлагаас нилээд өөрөөр “Tulqu bitiddim Irq aču ayγıl baŋa” гэж тайлсан бөгөөд монгол хэлээр орчуулбал “тогтоолгон бичив би, Мэргэ тавьж зөвлө надад /мэргэ нээж надад зөвлө/” гэсэн утгатай болно. Түрэг есөн Огуз нарын хооронд Туул голын хөвөөнд болсон тулалдааны үед хөшөө, бичээс үйлдэгдсэн бололтой хэмээн үзэж байна.

Түрэгүүдэд ялагдсан Огузын нэгэн язгууртан ард түмэн, цэрэг эрсээ тайвшруулан, ялагдаж түрэгийн харьяат болсон нь жирийн хэрэг биш мэргэ төлөгт

---

[6] Харжаубай С, Эртний түрэг руни дурсгалууд Төв азийн дундад эртний нүүдэлчдийн түүхийн сурвалж мөн, -ОУМЭ-ийн Үйх хурал, УБ., 1992, тал.90-94

[7] Харжаубай С, Эртний түрэг руни дурсгалууд Төв азийн дундад эртний нүүдэлчдийн түүхийн сурвалж мөн, -ОУМЭ-ийн Үйх хурал, УБ., 1992, тал.90-94

[8] Пүрэв О, Монгол бөөгийн шашин, УБ., 1999, тал.91-93

[9] Кляшторный С.Г, Руническая надпис из Восточной Гови, -Studia Turcica, Budapest, 1971, pp.249-258

[10] Osman Fikri Sertkaya, Göktürk harflı Çoyr yazıtı, -Orhun dergi, sayı 5, temmuz 1998

ингэж бууж зөвлөсөн, тэнгэр зарлигласан хэмээн итгүүлэхэд чиглэгдсэн нь хөшөөний бичээсэд “цаашид Илтириш хааныг дага” гэснээс тодорхой байна гэжээ. Гэрэлт хөшөөний бичээсийн агуулгаас үзвэл магадгүй энэ дурсгал нэгэн бөөд зориулагдсан байж болох юм. Ийн үзвэл хүн чулуу нь уг бөөгийн онго байхыг үгүйсгэх аргагүй юм. Доктор Н.Сэр-Оджав “Монгол оронд бурханы шашин дэлгэрч, эртнээс шүтэж ирсэн бөө, мөргөлийн онго шүтээнийг эвдлэн устгах болсноос үүдэн эрт үеийн шүтлэг тахилгын зүйл болох хүн чулуун хөшөөг эвдэн устгаж байжээ[11]” хэмээн тайлбарласан байна. Бурханы шашин Монголд их дэлгэрэх цагтаа бөө мөргөлтөн монголчуудын эртнээс тахиж байсан хүн чулууг эвдэн устгах нь бүү хэл харин тэдгээр хүн чулууг шашинд орж сахил авлаа хэмээн тунхаглаж хүндлэн тахих болсон хэмээн нэрт эрдэмтэн Б.Я.Владимирцов, Х.Пэрлээ нар санал нэгтэй үзжээ[12].

Эрдэмтэд хэдийгээр хүн чулууны эвдрэл, гэмтлийн талаар санал зөрөөтэй байгаа боловч хүн чулуу бөөгийн онго гэдэгт санал нэгтэй байсан нь илэрхий байна.

Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам дахь Билгэ хааны тахилын цогцолборыг Монгол, Туркийн эрдэмтэд малтан шинжилсэн бөгөөд 2002 оны малтлага судалгаагаар могой тамгатай зэл чулуу гарчээ. Могой тамга уйгурын тамга гэж үзвэл эл зэл чулуу уйгур нартай холбогдох нь мэдээж. Хэрвээ зэл чулууг алсан дайсны тоо гэж үзвэл дээр дурдсан есөн Огузтай хийсэн тулалдаанд алсан уйгур-огуз нарыг төлөөлүүлжээ гэж үзэх боломжтой. Харин оршуулгад оролцсон хүний тоо гэвэл ашидэ овгийнхон буюу уйгур нар иржээ хэмээн үзэж болно. Түрэгүүдийн дийлэнх нь бөө мөргөлтөн байсан хэмээн үзвэл эл чулууг Билгэ хааны дурсгалд зориулж бөө заарин нараас үйлдсэн байж болох талтай. Эцэст тэмдэглэхэд, Түрэг, Уйгурын үеийн гэрэлт хөшөөнд голдуу бөө хүний дурсгалд зориулсан эсвээс бөө удган хүний оролцоотойгоор босгосон гэрэлт хөшөө, зэл чулуу, суурь мэлхийд могой тамга сийлдэг байсан бололтой.

Номзүй

1. Баттулга Ц, Дэл уулын дурсгал , УБ., 2002
2. Владиморцов Б.Я, Этнолого-лингвистические исследования в Урге, Ургинском и Кентейском районах, СМ.Вып.II, Л., 1927
3. Дорж Д, Новогородова Э.А, Петроглифы монголии, УБ.,1975
4. Доржсүрэн Ц. Говь-Алтайн Цагаан голын хадны зураг, -Эртний судлал угсаатны зүйн бүтээл, УБ., 1963
5. Кляшторный С.Г, Руническая надпис из Восточной Гови, -Studia Turcica, Budapest, 1971
6. Пүрэв О, Монгол бөөгийн шашин, УБ., 1999
7. Пэрлээ Х, 1965 оны археологийн шинжилгээний олзноос, -ЭШ-ий өгүүллүүд, SH.f.YI.10, УБ., 1966
8. Сэр-Оджав Н, Монголын эртний түүх, УБ., 1977
9. Харжаубай С, Эртний түрэг руни дурсгалууд Төв азийн дундад эртний нүүдэлчдийн түүхийн сурвалж мөн, -ОУМЭ-ийн Ү их хурал, УБ., 1992

[11] Сэр-Оджав Н, Монголын эртний түүх, УБ., 1977, тал.136

[12] Владиморцов Б.Я, Этнолого-лингвистические исследования в Урге, Ургинском и Кентейском районах, СМ.Вып.II, Л.,1927, Пэрлээ Х, 1965 оны археологийн шинжилгээний олзноос, -ЭШ-ий өгүүллүүд, SH.f.YI.10, УБ., 1966, тал.93-103


10. Osman Fikri Sertkaya, Cengiz Alylmaz, Tsendiin Battulga, Album of the Turkish monuments in Mongolia, Ankara, 2001
11. Osman Fikri Sertkaya, Göktürk harflı Çoyr yazıtı, -Orhun dergi, sayı 5, temmuz-1998

Summary

The Snake Seals represented in monuments, rock paintings, tombstones and balbals. This seal concerned in period of Old Turkish and Uyghurish, generally.

The Snake seals represented in monuments, those dedicated for Shamans or built with Shamans.

Хавсралт



Чойрын хүн чулуу



Улхын булангийн мэлхий чулуу





Улхын булангийн мэлхий чулууны тамга